



## СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2020 оны 03 сарын 30 өдөр

Дугаар А/99

Сүхбаатар сум

Аймгийн Засаг даргын 2020 оны А/16, А/57, А/66 тоот захирамжид нэмэлт өөрчлөлт оруулах, бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг сунгах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6 "а", 29.3, Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн "Шинэ коронавирусийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай" 30 дугаар тогтоол, Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн "Бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг сунгах тухай" 102 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Дэлхий нийтэд хурдацтай тархаж байгаа /COVID-19/-ын цар тахалтай тэмцэх, халдвараас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах зорилгоор "Аймгийн Засаг даргын 2020 оны А/16, А/57 тоот захирамжид нэмэлт өөрчлөлт оруулах, бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг сунгах тухай" А/66 дугаар захирамжийн 4 дэх заалтын "3 дугаар сарын 30-ны" өдөр хүртэлх гэснийг өөрчилж, аймгийн хэмжээнд төрийн болон нутгийн захиргааны байгууллага, хуулийн этгээдийг гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг "2020 оны 4 дүгээр сарын 30-ны" өдөр хүртэл сунгасугай.

2. Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг сунгасантай холбогдуулан боловсролын бүх шатны сургалтын байгууллагын хичээл, сургалтын үйл ажиллагааг 2020 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийг хүртэл хугацаанд түр зогсоож, холбогдох арга хэмжээ авахыг Боловсрол, соёл, урлагийн газрын дарга /Ч.Жаргалсайхан/, аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга /Б.Энхбат/ нарт даалгасугай.


3. Нийтийн эзэмшлийн гудамж, зам талбай, орон сууц болон өрөө, тасалгаанд ариутгал халваргүйтгэл хийх арга хэмжээг тухай бүр, шуурхай зохион байгуулж ажиллахыг сумдын Засаг дарга нарт даалгасугай.

4. Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг сунгасан Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн 102 дугаар тогтоол, энэхүү захирамжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж ажиллахыг аймгийн Цагдаагийн газрын дарга, хурандаа /А.Энхбат/, Мэргэжлийн хяналтын газрын дарга /Ж.Отгонхүү/, Онцгой байдлын газрын дарга, хурандаа /Г.Баатар/, сумдын Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

C:\users\albanbichig2020\zahiramjA4.docx

430801310

5. Энэхүү захирамжийг иргэд, олон нийтэд мэдээлэх, холбогдох байгууллагуудад хүргүүлэх арга хэмжээ авч ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга /Д.Ёндонжамц/, сумдын Засаг дарга нарт тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА  ШОРГИЛ

